ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ ХХК

РИЛАЙНС ББСБ ХХК-ИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Улаанбаатар хот 2022 он	**Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:** “Лидер экаунт аудит” ХХК Утас: 88112654, 88472789 Цахим хаяг: leaderaudit.20@gmail.com

ГАРЧИГ

1.Хараат бус аудиторын тайлан 2

2.Аудитлагдсан санхүүгийн тайлан 5

3.Санхүүгийн тайлангийн тодруулга 9

4.Удирлагын захидал 15

“ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ” ХХК

2023 оны 02 сарын 09-өдөр

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо,
Төмөрчний гудамж - 8, 405 тоот
Утас: +976 7711-4519, 88472789, 88112654
И-мэйл: leaderaudit.20@gmail.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

РИЛАЙНС ББСБ ХХК-ИЙН УДИРДЛАГАД

Дүгнэлт

Бид Рилайнс ББСБ ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон санхүүгийн үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, Рилайнс ББСБ ХХК 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал болон уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын сандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Аудитын явцад бидний олж авсан баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж итгэж байна.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Сангийн сайдын батлсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг, хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт (АДБОУС)-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан тодруулагад санал өгөх хангалттай зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал зөвлөмжийг менежентийн захидалд тусгасан болно.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 95.1 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Рилайнс ББСБ ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

Лидер экаунт аудит ХХК
Захирал П.Шаравхорол
2023 оны 02 сарын 09

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

РИЛАЙНС ББСБ ХХК-ИЙН
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
(2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 НЭЭРХ)

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ТОДРУУЛГА	2021 ОНЫ 12-Р САРЫН 31	2022 ОНЫ 12-Р САРЫН 31
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрнгө	3.1	225,256,210.52	111,516,050.69
Зээл/Цэвэр/	3.2	1,362,860,268.26	2,020,648,479.37
Бусад авлага	3.3	71,923,817.87	95,877,821.12
Бусад хөрөнгө	3.4	33,110,694.85	8,666,305.96
Эргэлтийн хөрөнгийн дүн		**1,693,150,991.50**	**2,236,753,657.14**
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	3.5	14,096,082.27	17,246,790.86
Биет бус хөрөнгө	3.6	1,232,000.00	616,000.00
Эргэлтийн бус хөрнгө		**15,328,082.27**	**17,862,790.86**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		**1,708,479,073.77**	**2,254,616,448.00**
ӨР ТӨЛБӨР			
Богино хугацаат өр төлбөр			
Бусад өр төлбөр	3.7	-	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн		-	-
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		-	-
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ			
Хувьцаат капиталын дүн	3.8	1,400,000,000.00	1,900,000,000.00
Хуримтлагдсан үр дүн		**308,479,073.77**	**354,616,448.00**
Өмнөх үеийн үр дүн		80,363,351.79	479,0773.77
Тайлант үеийн үр дүн		228,115,721.98	354,137,374.23
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн		**1,708,479,073.77**	**2,254,616,448.00**
НИЙТ ӨР ТӨЛБӨР, ӨМЧИЙН ДҮН		**1,708,479,073.77**	**2,254,616,448.00**

2.2 Аудит хийсэн орлого үр дүнгийн тайлан

РИЛАЙНС ББСБ ХХК-ИЙН
АУДИТЛАГДСАН ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
(2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 НЭЭРХ)

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ТОД	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ХҮҮГИЙН ОРЛОГО		**338,932,190.13**	**470,737,782.01**
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	3.9	314,605,475.41	446,944,644.60
Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого		40,699,432.72	24,223,580.55
Хүүгийн орлогын буцаалт		16,372,718.00	430,443.14
Хүүгийн зардал		-	**5,101,370.00**
ЦЭВЭР ХҮҮГИЙН ОРЛОГО		**338,932,190.13**	**465,636,412.01**
ХҮҮГИЙН БУС ОРЛОГО	3.10	**19,631,668.57**	**89,073,655.61**
Гадаад валютын арилжааны орлого		-	-
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого		39,074.99	12,862.18
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого		9,780,948.61	11,555,502.20
Бусад үйлчилгээ		9,811,644.97	77,505,291.23
ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ	3.11	**124,595,066.10**	**194,752,250.12**
Арилжаа болон ханшийн тэгшитгэлийн зардал		42,383.01	-
Боловсон хүчний холбогдолтой зардал		79,901,700.12	140,782,363.34
Бусад зардал		44,650,982.97	53,969,886.78
ЦЭВЭР ХҮҮГИЙН БУС ОРЛОГО/ЗАРДЛЫН ДҮН		**(104,963,397.53)**	**(105,678,594.51)**
БОЛЗОШГҮЙ ЭРСДЛИЙН САН БАЙГУУЛАХААС ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/АЛДАГДАЛ		**233,968,792.60**	**359,957,817.50**
Эрсдлийн зардал		-	-
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/АЛДАГДАЛ		**233,968,792.60**	**359,957,817.50**
ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	3.12	3,548,838.00	2,243,428.00
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ/АЛДАГДАЛ		**230,419,954.60**	**357,714,389.50**
Орлогын татварын зардал	3.13	2,304,232.62	3,577,015.27
ЦЭВЭР АШИГ		**228,115,721.98**	**354,137,374.23**

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

РИЛАЙНС ББСБ ХХК-ИЙН
АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
(2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 НЭЭРХ)

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	**1,400,000,000.00**	**530,363,351.79**	**1,930,363,351.79**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-	-
Дахин илэрхийлэгдсэн үлдэгдэл	1,400,000,000.00	**530,363,351.79**	**1,930,363,351.79**
Тайлант үеийн үр дүн		228,115,721.98	**228,115,721.98**
Хуваарилагдсан ногдол ашиг		(450,000,000.00)	**(450,000,000.00)**
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	**1,400,000,000.00**	**308,479,073.77**	**1,708,479,073.77**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлэгдсэн үлдэгдэл	-	-	-
Ногдол ашиг		(308,000,000.00)	**(308,000,000.00)**
Хувьцаат капиталын өсөлт	500,000,000.00		**500,000,000.00**
Тайлант үеийн үр дүн		354,137,374.23	**354,137,374.23**
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	**1,900,000,000.00**	**354,616,448.00**	**2,254,616,448.00**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

РИЛАЙНС ББСБ ХХК-ИЙН

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
(2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 НЭЭРХ)

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	**(48,318,650.29)**	**(334,251,731.83)**
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	**2,068,393,162.94**	**3,461,411,758.36**
Зээлийн хүүгийн орлого	368,983,695.29	465,624,838.66
Харилцах дансны хүүгийн орлого	-	-
Гадаад валютын ханшийн зөрүү	39,074.99	12,862.18
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	1,443,400.00	5,204,505.50
Бусад үйлчилгээний орлого	1,697,926,992.66	2,990,569,552.02
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	**2,116,711,813.23**	**3,795,663,490.19**
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал	-	5,101,370.00
Үндсэн ба нэмэгдэл цалин	54,084,478.05	94,510,719.30
Ажилтануудад олгосон нөхөн олговор, тэтгэмж	5,060,000.00	-
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	14,308,667.65	25,879,411.28
Албан томилолт, сургалтын зардал	-	6,937,400.00
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	3,108,616.42	4,788,584.82
Шатахуун, холбоо, интернэт, слбэг хэрэгсэлд төлсөн зардал	9,255,015.95	6,409,631.44
Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал	1,664,122.06	2,474,333.00
Татвар, даатгалын төлсөн мөнгө	72,535,292.91	87,183,693.47
Зар сурталчилгаанд төлсөн мөнгө	80,000.00	100,000.00
Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан мөнгө	589,730.00	1,501,000.00
Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө	440,000.00	440,000.00
Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө	2,580,000.00	2,780,000.00
Ногдол ашгаар олгосон мөнгө	104,125,000.00	997,200.00
Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн бусад мөнгө	300,000.00	211,322,582.74
Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	1,848,580,890.19	3,345,237,564.14
ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	**(304,466,221.01)**	**220,556,572.00**
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	**51,925,000.00**	**222,800,000.00**
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага	**356,391,221.01**	**2,243,428.00**
Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал	3,548,838.00	1,775,428.00
Бусад	352,842,383.01	468,000.00
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	**(352,784,871.30)**	**(113,695,159.83)**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	578,041,081.82	225,256,210.52
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	225,256,210.52	111,561,050.69

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

ТОДРУУЛГА 1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

Үйл ажиллагаа:	Зээлийн үйл ажиллагаа
Бүртгэлийн дугаар:	9015002091
Регистрийн дугаар :	5689295
Байгуулагдсан огноо:	2013.03.26
Хувьцаа эзэмшигчийн тоо:	4 (2021.04.21 өдөр 1хасагдаж өөрчлөлт орсон)
Дүрмийн сан:	1,900,000.0 мянган төгрөг (2022 он дүрмийн нэмэгдсэн)
Тусгай зөвшөөрлийн дугаар:	ТЗ/101/286,2013.05.22 өдрийн 192 тогтоол
Компаний хаяг:	Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 18-р хороо, Гэгээнтэн оффис 901 тоот
Утас:	70119056, 99119056
Email:	enkhbayar.reliance@yahoo.com

ТОДРУУЛГА 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД

1. СТОУС-ын хэрэглээ, тасралтгүй үйл ажиллагаа

Баримталсан стандартын талаар: Санхүүгийн тайланг Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт (СТОУС) болон Сангийн сайдын 361 дугаар тушаалаар батлсан Аж ахуйн нэгж байгууллагад мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” аргачлалын дагуу бэлтгэсэн.

Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлагналын валют нь Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөг байна. Компанийн санхүүгийн тайлангуудаа үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр илэрхийлсэн байна.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайланг компани нь тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэсэн байна.

2. Нягтлан бодох бүртгэлийн гол бодолгууд

2.1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд мөнгө рүү түргэн хөрвөх чадвартай, үнэ цэнээ алдах эрсдэл багатай зүйлс хамаарна. Үүнд бэлэн мөнгө, банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө, хадгаламж зэргийг хамруулна.

2.2 Авлага

Компанийн авлага нь ажил, үйлчилгээг зээлээр борлуулж, төлбөрийг худалдан авагч болон бусад этгээдээс нэхэмжилж буй мөнгөний дүн юм.

2.3 Бараа материал

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар тайлагнана. Цэвэр боломжит үнэ цэнийг бизнесийн хэвийн ажиллагааны үеийн бараа материалын борлуулах үнээс бараа материалыг иж бүрдэл болгох зардал ба борлуулах зардлыг хасч тооцно. Бараа материалын өртгийг жинлэсэн дундажийн өртгийг аргаар тооцох бөгөөд уг бараа материалыг одоогийн байршил, нөхцөлд авчрахтай холбоотой гарсан зардлуудыг өртөгт шингээнэ.

2.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анхны удаа өртгөөр нь бүртгэх ба анхны хүлээн зөвшөөрөлтийн дараах тайлант үед үндсэн хөрөнгийг түүний өртгөөс аливаа хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралт хассан цэвэр дүнгээр тайлагнадаг.

Үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг дараах байдлаар тогтооно.

- Барилга байгууламж 25-40
- Тоног төхөөрөмж 10 жил
- Тээврийн хэрэгсэл 10 жил
- Тавилга, эд хогшил 5-10 жил
- Компьютер, тоног төхөөрөмж 2-3 жил

Ашиглах эрхийн хөрөнгийн ашиглах хугацааг тодорхойлохдоо гэрээний нөхцөл эсвэл өмчлөлд байгаа ижил төстэй хөрөнгийн ашиглах хугацааны аль багаар тогтооно. Материаллаг дүнтэй үлдэх өртөг тооцоолол болон хөрөнгийн ашиглах хугацааны тооцооллыг багадаа жилд нэг удаа шинэчлэнэ.Үндсэн хөрөнгийн данснаас хассан, ашиглалтаас гаргаснаас үүссэн олз, гарзыг тухайн хөрөнгийн борлуулалт болон дансны үнийн зөрүүгээр тодорхойлох ба олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

2.5 Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгийг анхны өртгөөр нь хүлээн зөвшөөрч бүртгэх бөгөөд дараа үеэдэд түүний өртгөөс нь хуримтлагдсан хорогдуулга, үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр илэрхийлдэг. Биет бус хөрөнгийн ашиглагдах хугацааг дараах байдлаар тогтооно.

- Программ хангамж Лизенцийн хугацаанд
- Газар эзэмших эрх Эрхийн хугацаанд

2.6 Өр төлбөр

Харилцагч байгууллага, хувь хүнээс авсан бараа, ажил, үйлчилгээ авсныхаа төлөө тэдэнд мөнгө эсвэл бусад хөрөнгөөр төлбөр төлөх үүрэг хүлээсэн санхүүгийн хариуцлага бөгөөд ирээдүйд төлөгдөх өртгөөрөө хэмжигдэнэ.

2.7 Гадаад валютаарх ажил гүйлгээ болон үлдэгдэл

Гадаад вадютаар гарсан ажил гүйлгээг тухайн өдрийн Монгол банкны албан ханшаар төгрөгт хөрвүүлж төгрөг, юалютаар давхар бүртгэдэг. Гадаад валютаар бүртгэгдсэн мөнгө хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлан тэнцлийн өдрийн ханшаар хөрвүүлэн тайлагнадаг. Ажил гүйлгээнээс үүссэн валютын ханшийн олз, гарзыг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. жилийн эцсийн валютын ханшаар хөрвүүлсэнтэй холбоотой олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Зах зээлийн үнээр хэмжигддэгээс бусад мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ хийгдсэн өдрийн түүхэн ханшаар бүртгэж, тайлант жилийн эцэст тэгшитгэл хийхгүй.

2.8 Хувьцаат капитал

Энгийн хувьцаа нь хувь нийлүүлэгчдийн оруулсан хөрөнгийг харуулдаг бөгөөд хувьцааны нэрлэсэн үнэ болон хувьцааны тоо ширхэгийг санхүүгийн тайланд толилуулдаг.

2.9 Орлого

Бараа, ажил, үйлчилгээ борлуулсны орлого, хөрөнгө бусдад ашиглуллсны орлогыг хүлээн авсан, эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй бодит үнэ цэнээр хэмжих ба гарсан аливаа худалдаа, үйлчилгээний буцаалт, хөнгөлөлт, үнийн бууралт зэргийг хассан цэвэр дүнгээр орлогыг хүлээн зөвшөөрдөг.

2.10 Санхүүгийн орлого ба санхүүгийн зардал

Санхүүгийн орлого нь хүүний орлогоос бүрдэх бөгөөд ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөн бүртгэлд бүртгэгдэнэ. Хүүний орлогыг үр ашигт хүүний аргыг ашиглан орлогын тайланд хуримтлуулан хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн зардал нь зээлийн хүүгийн зардлаас бүрдэх ба ашиг алдагдлаар алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөн бүртгэлд бүртгэгдэнэ.

2.11 Зардал

Зардлыг нягтлан бодох бүртгэлийн аккруэль суурьт зарчмын дагуу эдийн засгийн ирээдүйн үр ашгийг хэмжиж болохуйц хөрөнгийг багасгах буюу өр төлбөрийг нэмэгдүүлэхээр байвал хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

ТОДРУУЛГА 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

3.1 Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Бэлэн мөнгө	3,953,419.62	2,204,476.44
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах	221,302,790.90	109,356,574.25
Нийт дүн	**225,256,210.52**	**111,561,050.9**

Мөнгөтэй адилтгах хөрөнгийн харилцах дансны үлдэгдлийг банкны хуулгаар баталгаажуулав. Бэлэн мөнгөний үлдэгдлийн тооллогод оролцоогүй болно.

3.2 Зээл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Зээл/цэврээр/	**1,362,860,268.26**	**2,020,648,479.37**
Нийт зээл	**1,555,729,232.26**	**2,122,048,479.37**
Хэвийн зээл	1,344,759,332.26	1,999,813,479.37
Хугацаа хэтэрсэн зээл	-	-
Чанаргүй зээл	**210,969,900.00**	**122,235,000.00**
Хэвийн бус зээл	-	-
Эргэлзээтэй зээл	42,569,900.00	41,670,000.00
Муу зээл	168,400,000.00	80,565,000.00
Зээлийн эрсдлийн сан	(192,868,964.00)	(101,400,000.00)

2022 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн тайланд нийт зээлийн 94.2 хувийг хэвийн зээл, 5.8 хувийг чанаргүй зээл эзэлж байна. Тайлант жилд цэвэр зээлийн дүн нь нийт хөрөнгийн 94.1 хувийг эзэлж байна. Нийт зээлд хэвийн зээлийн эзлэх хувь 94.2 хувь байгаа нь зээлийн үйл ажиллагаа тогтвортой явагдаж байна гэсэн дүгнэлтэнд хүрч байна. Зээлийн эрсдлийн санд 101,400,000.00 төгрөг байршуулсан байгаа өмнөх жилээс 47.4 хувиар буурсан байна.

3.3 Бусад авлага

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Бусад авлага	19,832,671.01	40,665,532.85
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	52,091,146.86	55,212,288.27
Нийт дүн	**71,923,817.87**	**95,877,821.12**

3.4 Бусад хөрөнгө

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	3,673,244.02	8,666,305.96
Хэвийн өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	29,437,450.83	-
Нийт дүн	**33,110,694.85**	**8,666,305.96**

3.5 Үндсэн хөрөнгө

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Эд хогшил	9,920,935.00	10,356,935.00
Хуримтлагдсан элэгдэл	(6,958,707.25)	(7,496,343.05)
Техник хэрэгсэл	24,305,854.54	32,967,466.54

Хуримтлагдсан элэгдэл	(13,172,000.02)	(18,581,267.63)
Нийт дүн	**14,096,082.27**	**17,246,790.86**

3.6 Биет бус хөрөнгө

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Биет бус хөрөнгө	1,232,000.00	616,000.00
Нийт дүн	**1,232,000.00**	**616.000.00**

3.7 Бусад өр төлбөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Цалингийн өглөг	-	-
ХХОАТ-ын өглөг	-	-
Орлогын албан татварын өглөг	-	-
Үндсэн хөрөнгийн албан татвар	-	-
Бусад өглөг	-	-
Нийт дүн	-	-

3.8 Хувьцаат капитал

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Хувь нийлүүлсэн хөрөнгө	1,400,000,000.00	1,900,000,000.00
Нийт хувьцаа/ширхэг/	1,400,000 ш	1,900,000 ш
Нийт дүн	**1,400,000,000.00**	**1,900,000,000.00**

2021 оны санхүүгийн тайлангаар 1,400,000,000 төгрөгийн хувьцаат капитал бүртгэлтэй байсан бөгөөд тайлант онд хувьцаат капиталыг 500,000,000 төгрөгөөр нэмэгдүүлж 2022.12.31-ний үлдэгдлээр хувьцаат капитал нь нэг бүрийн үнэ 1,000 төгрөг 1,900,000 ширхэг хувьцаа буюу 1,900,000,000 төгрөгийн хувьцаат хөрөнгө бүртгэлтэй байна.

3.9 Хүүгийн орлого

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	314,605,475.41	368,082,287.68
Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	40,699,432.72	24,223,580.55
Хүүгийн орлогын буцаалт	16,372,718.00	430,443.14
Бусад санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал	-	5,101,370.00
Цэвэр хүүгийн орлогын дүн	**338,932,190.13**	**465,636,412.01**

3.10 Хүүгийн бус орлого

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого	39,074.99	12,862.18
Арилжааны цэвэр орлого	-	-
Санхүүгийн үйлчилгээний орлого	**19,592,593.58**	89,060,793.43
Үйлчилгээний хураамж шимтгэлийн орлого	9,780,948.61	11,555,502.20
Бусад үйлчилгээ	9,811,644.97	77,505,291.23
Хүүгийн бус орлогын дүн	**19,631,668.57**	**89,073,655.61**

3.11 Хүүгийн бус зардал

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Арилжаа болон ханшийн тэгшитгэлийн зардал	**42,383.01**	**-**
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал	42,383.01	-
Боловсон хүчний холбогдолтой зардал	**79,901,700.12**	**140,782,363.34**
Үндсэн болон нэмэгдэл цалин	66,769,031.39	116,451,580.29
Ажилтнуудад олгосон нэмэгдэл цалин, урамшуулал	-	-
Ажилтнуудад олгосон тэтгэмж, нийгмийн халамж	5,060,000.00	-
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл	7,962,668.93	13,521,963.55
Сургалтын зардал	60,000.00	-
Бусад зардал	49,999.80	3,871,419.50
Албан томилолт	-	6,937,400.00
Бусад зардал	**44,650,982.97**	**53,969,886.78**
Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан зардал	6,635,595.05	1,537,820.25
Аудитын төлбөр, мэргэжлийн үйлчилгээний зардал	440,000.00	440,000.00
Даатгал	59,400.00	59,500.00
Зохицуулалтын хураамжийн зардал	2,580,000.00	2,780,000.00
Түрээс	14,400,000.00	17,400,000.00
Ашиглалтын зардал	3,108,616.42	4,788,548.82
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	4,905,421.24	6,562,903.41
Үндсэн хөрөнгийн урсгал засвар	-	-
Харилцаа холбоо, интернэт	2,146,904.95	2,413,882.44
Шатахуун болон тээврийн зардал	3,495,680.00	3,722,500.00
Сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ	4,881,531.00	7,284,549.00
Шимтгэлийн зардал	-	-
Хөдөлсөр хамгаалал, галын аюулаас хамгаалах зардал	-	-
Автомажуулалттай холбоотой урсгал зардал	-	-
Зар сурталчилгаа, маркетингийн судалгааны зардал	80,000.00	100,000.00
Бичиг хэргийн зардал	1,019,787.06	1,354,408.00
Үл хөдлөх хөрөнгийн татвар	69,752.00	1,791,780.21
Ариун цэврийн зардал	644,335.00	1,119,925.00
Бусад зардал	183,960.25	2,614,033.25
Хүүгийн бус зарлагын дүн	**124,595,066.10**	**194,752,250.12**

Тайлант хугацаанд нийт 194,752,250.12 төгрөгийн үйл ажиллагааны зардал гаргасан байна. Нийт зардлын 72,2 хувийг боловсон хүчний холбогдолтой зардал, 27.8 хувийг бусад үйл ажиллагааны зардалд зарцуулжээ. Зардлыг бүртгэхдээ анхан шатны баримтыг ибаримтаар бүрдүүлж, зөв ангилан бүртгэсэн байна.

3.12 Үндсэн бус үйл ажиллагааны зардал

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Баяр ёслолын зардал	3,548,838.00	1,775,428.00
Бусад	-	468,000.00
Нийт дүн	**3,548,838.00**	**2,243,428.00**

3.13 Орлогын татварын зардал

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Орлогын татварын зардал	2,304,232.62	3,577,015.27

Нийт дүн	**2,304,232.62**	**3,577,015.27**

3.14 Холбоотой талуудын ажил гүйлгээ

Санхүүгийн тайлангийн зорилгоор талууд нь НББОУС24 буюу "Холбоотой талын тодруулга"-д тодорхойлсноор хэрвээ тухайн компани нь нөгөө этгээдийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой шийвдэр гаргалтанд нөлөө үзүүлэх буюу хянах чадвартай бол холбоотой талууд гэж тодорхойлно.

Холбоотой талуудын магадлыг авч үзэхдээ хуулийн хэлбэрээс илүү эдийн засгийн холбоо хамаарлыг авч үзнэ гэж заасны дагуу холбоотой талуудын мэдээллийг татварын тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулга хэсэгт тайлагнах үүрэгтэй

3.15 Балансын дараах үйл явдал

2023 оны 01 сарын 01-нээс 2023 оны 02 сарын 09-ны өдөр хүртэл Рилайнс ББСБ ХХК-ийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөхүйц, тодруулах шаардлагатай үйл явдал гараагүй байна.

Аудитор Ш.Уянга

2022 оны 02 сарын 09-ний өдөр